Golomt Capital®

# Хөрөнгийн зах зээлийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв 2022.02.28

## Олон улсын хөрөнгийн зах зээл

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

2022 он 02 сарын 28

## ТОВЧ

- ОХУ Украин руу довтолсноор европт эрчим хүчний үнэ өслөө
- Украйны засгийн газар болон банкны вэбсайтууд кибер халдлагад өртжээ
- Жижиг дайралт болон бөмбөгдөлт нь хөрөнгийн зах зээлийг 5 орчим хувиар унагадаг
- Украйны засгийн газар криптовалютын хандиваар 10 сая гаруй ам.доллар босгожээ
- Цагаан ордноос ОХУ-ын хяналтад байдаг "Хойд урсгал 2" байгалийн хийн хоолой болон ялангуяа түүний барилгын компаниудын үйл ажиллагаанд хориг тавихаа зарлалаа.

| | |
|---|---|
| Dow Jones | 34,058 |
| S&P 500 | 4,384 |
| Nasdaq | 13,694 |
| DAX | 14,567 |
| FTSE | 7,489 |
| S&P/ASX | 7,015 |
| HANG SENG | 24,431 |

## АНУ-ын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | 1 жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| Dow Jones | 2.51% | -0.06% | -1.92% | -6.27% | 8.00% | 30.86% |
| S&P 500 | 2.25% | 0.82% | -1.07% | -8.01% | 12.37% | 56.39% |
| Nasdaq | 1.64% | 1.08% | -0.55% | -12.47% | 0.78% | 80.30% |

*2022 оны 02 сарын 28-ний 10:00*

**DJIA 34,058** дээр хаагдсанаар **0.06** хувь уналаа. **SP500** индексийн хувьд **0.82** хувь өссөн долоо хоног өнгөрлөө.

## Европын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | 1 жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| DAX | 3.67% | -1.11% | -4.91% | -8.29% | 3.96% | 25.56% |
| FTSE | 3.91% | 0.07% | 0.31% | 1.42% | 13.67% | 5.39% |

*2022 оны 02 сарын 28-ний 10:00*

**FTSE 100** (Лондонгийн биржийн топ-100 компани) индекс **0.07** хувийн өсөлттэй байсан бол **DAX** (Франкфуртийн биржийн топ 30 компани) **1.11** хувийн өсөлт мөн үзүүлжээ.

## Ази номхон далайн индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | 1 жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| S&P/ASX 200 | 0.28% | -3.02% | 0.38% | -5.77% | 3.32% | 13.28% |
| Hang Seng | -1.36% | -7.17% | -4.72% | -4.10% | -23.82% | -22.12% |

*2022 оны 02 сарын 28-ний 10:00*

**S&P/ASX200** (Австралийн биржийн топ 200 компани) индекс хувь **3.02** хувь унасан бол **Hang Seng** (ХонКонгийн биржийн индекс) **1.36** хувь уналт үзүүлсэн байв.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

2022 оны 02 сарын 28

## Олон улсын хөрөнгийн зах зээл

- Мягмар гарагт ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Украйны зүүн хэсэгт цэргээ оруулах тушаал өгсний дараа Оросын хөрөнгийн үнэ цэн дэлхийн хэмжээнд огцом буурлаа. В.Путины мэдэгдлийн дараа ам.долларын ханш бараг 81 рубль болж өсөн нь рублийн үнэ цэнийг сүүлийн хоёр жилд байгаагүйгээр бууруулсан ч хэсэг хугацааны дараа 79 болж сэргэсэн юм. Тодруулбал, Украины гривенийн ханш рублийн эсрэг 2.1 хувиар унасан бол Оросын MOEX хөрөнгийн биржийн индекс өглөө 6 хувиар унаж нээгдэн 2020 оны дунд үеэс хойшхи хамгийн доод цэгтээ хүрснээр RTS индекс 6.5 хувиар буурсан байна.

- Европын холбоо нь дэлхийн байгалийн хийн хамгийн том импортлогч юм. Тус холбооны Эрчим Хүчний Ерөнхий газрын мэдээлснээр “Бид ОХУ-аас нийт хэрэглээнийхээ 41 хувийг авдаг нь байдлыг улам тогтворгүй болгож байна” гэж мэдээлжээ. ОХУ Украин руу довтолсноор эрчим хүчний үнэ өссөн бөгөөд 2014 оноос хойш анх удаа олон улсын Брентийн түүхий нефтийн ханш 100 ам.долларыг давжээ. Байгалийн хийн үнэ эхний дайралтын дараа 6.5 хувиар өсөж, пүрэв гарагийн үд дунд гэхэд дахин 2 хувиар нэмж өсөв.

- Жижиг дайралт болон бөмбөгдөлт нь хөрөнгийн зах зээлийг 5 орчим хувиар унагадаг. Ковидоос болоод яг таг таамаглахад бэрхтэй болсон хөрөнгийн зах зээл дахиад л уймарч эхэллээ. Хэдхэн хоногийн өмнө хөрөнгийн зах зээлд инфляц гол сэдэв байсан бол ОХУ болон Украйны хооронд дайн дэгдэж магадгүй болсон нь тус зах зээл унах шалтгаан болж байна. 1941 оноос хойш тохиосон олон улсын томоохон зөрчилдөөн нь хөрөнгийн зах зээл болон S&P 500 индексд хэрхэн нөлөөлж байсныг эргэн харъя.Харьцангүй жижиг дайралтууд болон бөмбөгдөлт нь хөрөнгийн зах зээлд 5 орчим хувийн уналтыг авчирдаг бол томоохон дайн дэгдвэл 15 хүртэл хувиар унаж байжээ. Кембрижийн Их Сургуулиас Иракийн дайны явцад хийсэн судалгаагаар тухайн үед АНУ-ын индекс 15 хувиар унасан байна. Доорх хүснэгтээс харвал дундаж уналт 22 хоног үргэлжилсэн бол эргээд уналтаа 47 хоногт нөхсөн байна.

| | | S&P 500 уналт | | Календарын өдөр | |
|---|---|---|---|---|---|
| Зах зээлийн шок үйл явдлууд | Үйл явдлын өдрүүд | Тухайн өдөрт | Нийт уналт | Уналтын хугацаа | Эргээд өссөн хугацаа |
| Сауди Арамкогийн дроны дайралт | 09/14/2019 | -0.3% | -4.0% | 19 | 41 |
| Хойд Солонгосын пуужингийн дайралт | 07/28/2017 | -0.1% | -1.5% | 14 | 36 |
| Сирийн бөмбөгдөлт | 04/07/2017 | -0.1% | -1.2% | 7 | 18 |
| Бостонгийн марафоны бөмбөгдөлт | 04/15/2013 | -2.3% | -3.0% | 4 | 15 |
| Лондонгийн метроны бөмбөгдөлт | 07/05/2005 | 0.9% | 0.0% | 1 | 4 |
| Мадридын бөмбөгдөлт | 3/11/2004 | -1.5% | -2.9% | 14 | 20 |
| АНУ террорист дайралт | 9/11/2001 | -4.9% | -11.6% | 11 | 31 |
| Иракын Кувайтруу хийсэн дайралт | 8/2/1990 | -1.1% | -16.9% | 71 | 189 |
| Рэйген буудлага | 3/30/1981 | -0.3% | -0.3% | 1 | 2 |
| Йом Киппурын дайн | 10/6/1973 | 0.3% | -0.6% | 5 | 6 |
| Мюнхений олимп | 9/5/1972 | -0.3% | -4.3% | 42 | 57 |
| Вьетнамын дайралт (Tet Offensive) | 1/30/1968 | -0.5% | -6.0% | 36 | 65 |
| Араб болон Израйлын дайн | 6/5/1967 | -1.5% | -1.5% | 1 | 2 |
| Тонкины булан дахь мөргөлдөөн | 8/2/1964 | -0.2% | -2.2% | 25 | 41 |
| Кеннедигийн аллага | 11/22/1963 | -2.8% | -2.8% | 1 | 1 |
| Кубын пуужингийн дайралт | 10/16/1962 | -0.3% | -6.6% | 8 | 18 |
| Суэцийн хямрал | 10/29/1956 | 0.3% | -1.5% | 3 | 4 |
| унгарын бослого | 10/23/1956 | -0.2% | -0.8% | 3 | 4 |
| Хойд Солонгос Өмнөдрүү хийсэн дайралт | 6/25/1950 | -5.4% | -12.9% | 23 | 82 |
| Сувдан эргийн халдлага | 12/7/1941 | -3.8% | -19.8% | 143 | 307 |
| Дундаж | | -1.2% | -5.0% | 22 | 47 |

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Golomt Capital®

**Хөрөнгийн зах зээлийн тойм**

2022 оны 02 сарын 21

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд




## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.